



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2018 оны 10 сарын 30 өдөр

Дугаар 192

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын  
худалдаагаар худалдах зөвшөөрөл  
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 128 дугаар тогтоолын 5.2, 6.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Шүүхийн ерөнхий зөвлөлийн харьяа шүүхийн Тамгын газруудын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид засаж, сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй болох нь тогтоогдсон нийт 65,367,500.00 (жаран таван сая гурван зуун жаран долоон мянга таван зуун) төгрөгийн балансын үнэ бүхий 4 автомашиныг нээлттэй дуудлага худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2.Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Н.Лүндэндорж, Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн Тамгын газрын дарга Н.Батхүү, Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Тамгын газрын дарга Д.Одхүү, Дорноговь аймаг дахь шүүхийн Тамгын газрын дарга Б.Бээжин, Хэнтий аймгийн Бор-Өндөр сум дахь шүүхийн Тамгын газрын дарга Л.Наянтай нарт дор дурдсан арга хэмжээг авч ажиллахыг даалгасугай:

2.1.Автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.2.Дуудлагын худалдаанаас олох орлогыг зохих захиргааны актын дагуу (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4.Энэ тогтоолын биелэлтийг 2019 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.


ДАРГА

Ц.НЯМ-ОСОР

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ГАВАА

0002385



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2018 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн  
498 дугаар тогтоолын хавсралт

### НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ

| Д/д                                                                                                                       | Автомашинны марк, улсын дугаар, арал                                   | Үйлдвэрлэсэн,<br>ашиглалтад<br>орсон он | Явсан км | Балансын үнэ                                                       | Үлдэгдэл үнэ | Сэргээн<br>босголын<br>зардал<br>(төгрөг) | Худалдах<br>доод үнэ           | Дэнчингийн<br>хэмжээ                   |
|---------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------|-----------------------------------------|----------|--------------------------------------------------------------------|--------------|-------------------------------------------|--------------------------------|----------------------------------------|
| Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн тамгын газрын балансад бүртгэлтэй автомашин |                                                                        |                                         |          |                                                                    |              |                                           |                                |                                        |
| 1                                                                                                                         | Суудлын автомашин, Исузу Визард,<br>03-57 УНУ, UES73FW4104053          | 1998/2007                               | 154831   | 12,210,000.0                                                       | 0            | -                                         | 1,500,000.00                   | 375,000.00                             |
| Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн тамгын газрын балансад бүртгэлтэй автомашин  |                                                                        |                                         |          |                                                                    |              |                                           |                                |                                        |
| 2                                                                                                                         | Суудлын автомашин, Хонда СРВ,<br>03-58 УНУ, RD25104229                 | 2000/2011                               | 133864   | 14,970,000.0                                                       | 0            | -                                         | 2,500,000.00                   | 625,000.00                             |
| Дорноговь аймаг дахь шүүхийн тамгын газрын балансад бүртгэлтэй автомашин                                                  |                                                                        |                                         |          |                                                                    |              |                                           |                                |                                        |
| 3                                                                                                                         | Суудлын автомашин, Тоёота Ланд Круйзер-80, 14-<br>21 ДГО, FZ1800065344 | 1994/2008                               | 285721   | 22,325,000.0                                                       | 0            | -                                         | 2,000,000.00                   | 500,000.00                             |
| Хэнтий аймгийн Бор-Өндөр сум дахь шүүхийн тамгын газрын балансад бүртгэлтэй автомашин                                     |                                                                        |                                         |          |                                                                    |              |                                           |                                |                                        |
| 4                                                                                                                         | Суудлын автомашин, Тоёота Хайлукс,<br>56-ХЭА, RZN185-9026150           | 1999/2008                               | 265000   | 15,862,500.0                                                       | 0            | -                                         | 2,500,000.00                   | 625,000.00                             |
| НИЙТ ДҮН                                                                                                                  |                                                                        |                                         |          |                                                                    |              |                                           |                                |                                        |
|                                                                                                                           |                                                                        |                                         |          | 65,367,500.0                                                       |              |                                           | 8,500,000.0                    | 2,125,000.0                            |
|                                                                                                                           |                                                                        |                                         |          | (харан таван сая гурван зуун жаран долоон мянга таван зуун төгрөг) |              |                                           | (найман сая таван зуун мянган) | (хоёр сая нэг зуун хорин таван мянган) |